



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2026 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам (ЭЧХН)-ын
шинэчилсэн дүрмийг бүртгэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, Б.Батцэрэн, Н.Батчимэг, Э.Золзаяа, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Ундрах, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Х.Эрдэнэсувд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам (ЭЧХН)-ын шинэчилсэн дүрмийг бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч Ц.Цогтын танилцуулснаар хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Эрх чөлөөг хэрэгжүүлэгч намын дарга Ш.Төмөрсүхээс “Намын 2026 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн ээлжит 9 дүгээр Их хурлаар намын дүрмийг хуулийн 15.2-т тавигдах нийтлэг шаардлага, хэлбэрт нийцүүлэх зорилгоор намын хөтөлбөр, дүрмийн шинэчилсэн найруулгын өөрчлөлтийг хэлэлцэн бүртгүүлэхээр хүргүүлж байна” гэсэн өргөдлийг 112 хуудас баримт бичиг, 1 ширхэг флаш, Зууны мэдээ сонины хамт 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдөр Улсын дээд шүүхэд ирүүлсэн байна.

Эрх чөлөөг хэрэгжүүлэгч намын 2026 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн намын ээлжит 9 дүгээр Их хурлын 01 дүгээр шийдвэрээр шинэчлэн баталсан дүрмийн зарим зүйл, заалтын агуулга нь тодорхой бус, ойлгомжгүй, техникийн шинжтэй алдаа байсан тул 2026 оны 04 дүгээр сарын 10, 16-ны өдрийн сонсох ажиллагаагаар тодруулсан ба нэмэлтээр 93 хуудас баримт бичиг хүлээн авсан.

Дээрх өргөдөл, хавсралт баримтуудыг Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга) болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын 2.5-д заасны дагуу шалгах ажиллагааг хэрэгжүүлж, журмын 6.6-д зааснаар нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд “Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-тай нийцүүлэх арга хэмжээг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор авч

хэрэгжүүлэх бөгөөд уг өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлнэ” гэж заасан.

Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам нь хуульд заасан хугацааны дотор өөрийн намын хөтөлбөр, дүрмийг шинэчлэн бүртгүүлэх өргөдлийг шүүхэд 2 удаа ирүүлсэн боловч тодорхой алдаа, зөрчилтэйн улмаас бүртгээгүй байна.

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар зөрчлөө зассаны үндсэн дээр дахин нэг удаа 60 хоногийн дотор намын дүрмээ бүртгүүлж болохоор шийдвэрлэсний дагуу тухайн намаас 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдөр өргөдөл ирүүлсэн, Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д заасан шаардлагад нийцүүлэн дүрмээ баталсан тул Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Эрх чөлөөг хэрэгжүүлэгч намын шинэчилсэн дүрмийг дараах үндэслэлээр бүртгэж шийдвэрлэв.

Нэг. Намын Их хурлыг хуралдуулсан процесс болон намын дүрмийг шинэчлэн батлах тухайд:

1.1. Эрх чөлөөг хэрэгжүүлэгч намын дүрэм (2024 он)-ийн 4.1.1.2-т “Намын бүх шатны хурлын ирцийг гишүүд, төлөөлөгчдийн 50-иас дээш хувьтай бол тухайн хурлыг хүчинтэйд тооцно”, 4.1.4-т “Намын дарга, Ерөнхий нарийн бичгийн дарга /ЕНБ дарга/, намын дэд дарга нарыг намын Удирдлага гэж ойлгоно”, 4.1.7.5-д “Гүйцэтгэх зөвлөл нь намын удирдлагын шийдвэрээр бүх шатны хурлын тов зарлах, оролцох гишүүдийн тоо, ирцийг бүрдүүлэх, хурал зохион байгуулах газрыг тогтоох, хэвлэл мэдээллээр зарлах, хэлэлцэх асуудлыг боловсруулан санал оруулах, өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах” гэж заасан.

Өргөдөлд хавсарган ирүүлсэн баримтуудаас үзвэл, тус намын Удирдлагын 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01 дүгээр шийдвэрийг үндэслэн Гүйцэтгэх зөвлөл 2025 оны 02 дугаар сарын 02-ны өдөр хуралдаж, намын ээлжит 9 дүгээр Их хурлыг 2026 оны 03 дугаар сарын 14-ний өдөр товлон зарлаж, Их хуралд сонгогдох төлөөлөгчдийн тоог орон нутагт салбаргүй тул аймаг, сум, нийслэл, дүүргээс намын зорилго, үзэл баримтлалыг дэмжин намын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог тухайн орон нутгийн намын гишүүдээс хурлын төлөөлөгчдийг ажлын алба бүрдүүлж, орон нутгаас 19, Улаанбаатар хотын дүүргээс 20, нийт 39 төлөөлөгч (эмэгтэй 19 буюу 48.7 хувь, 20 эрэгтэй буюу 51.3 хувь) оролцуулахаар шийдвэрлэж, 01 дүгээр шийдвэрийг гаргажээ.

Уг хуралд оролцсон Гүйцэтгэх зөвлөлийн гишүүдийн нэрсийг шалгахад, Улс төрийн бодлогын зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 01 дүгээр шийдвэрээр сонгогдсон гишүүд мөн бөгөөд ээлжит 9 дүгээр Их хуралд оролцох төлөөлөгчдөд хурлын тов, зохион байгуулагдах газрын талаарх мэдээллийг Зууны мэдээ сонины 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн №29 (7771) дугаарт нийтлэн мэдээлсэн, мөн намын цахим бүртгэлийн систем, групп чат болон утсаар хүргэсэн байна.

Эрх чөлөөг хэрэгжүүлэгч намын ээлжит 9 дүгээр Их хурал 2026 оны 03 дугаар сарын 14-ний өдөр танхимын хэлбэрээр зохион байгуулагдаж, тус хуралд 39 төлөөлөгч оролцохоос 33 төлөөлөгч оролцсон (эмэгтэй 14 буюу 42 хувь, эрэгтэй 19 буюу 57 хувь) нь мөн өдрийн Тооллогын комиссын 03 дугаар тогтоол, хурлын ирцийн

бүртгэл, фото зураг, дүрс бичлэг болон бусад баримтаар тогтоогдож байх тул тухайн хурлын процесс зөрчилгүй байна.

1.2.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 17 дугаар зүйлийн 17.2-т “Намын удирдах дээд байгууллага дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ.” гээд 17.2.1-д “намын дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж, Эрх чөлөөг хэрэгжүүлэгч намын дүрэм (2024 он)-ийн 4.1.1.7-д “Намын удирдах дээд байгууллага нь дараах бүрэн эрхтэй”, 4.1.1.7.1-д “Намын дүрмийг батлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах” гэж тус тус заасан.

Өмнө нь, тухайн намаас намын дүрмийг шинэчлэн бүртгүүлэх өргөдлийг 2024 оны 10 дугаар сарын 24, 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр тус тус ирүүлснийг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор “хурлын процесс зөрчилтэй, намын дүрэм хуульд нийцээгүй” гэсэн 4 үндэслэл бүхий 17 алдаа зөрчлийг дурдан бүртгэхээс татгалзсан, мөн Улсын дээд шүүхийн 2026 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 03/71 дугаартай албан бичгээр “өмнөх тогтоолын зөрчил бүрэн арилаагүй, ... Их хурлын төлөөлөгчдийг сонгох журамтай холбоотой асуудлыг ижил агуулга бүхий хэд хэдэн хэсгээр дугаарлалт байхгүйгээр давхардуулан оруулсан нь ойлгомжгүй, гишүүний татварыг хэн, хаанаас тогтоох, бүртгэл хяналтыг хэн хариуцах, хугацаандаа татвараа төлөөгүй тохиолдолд авах арга хэмжээ, санхүүгийн удирдах ажилтныг хэн нэр дэвшүүлэх болон намын бүтцийн байгууллагуудын хэлэлцэх асуудлыг тогтоох эрх хэмжээ, шийдвэр гаргах, санал гаргах журмыг тусгаагүй, намын гишүүнийг хасах зохицуулалт нь ойлгомжгүй, сахилгын шийтгэл оногдуулах хөөн хэлэлцэх хугацаа, төлөөллийн төв байгууллагыг нэг жилд хэдэн удаа хуралдахыг тодорхойлоогүй, намын гүйцэтгэх, төлөөллийн төв байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувь байх хуулийн шаардлагыг бүрэн хангаагүй, намын дүрэмд төрийн улс төрийн албан тушаал, намын удирдах албан тушаалаас чөлөөлөх зохицуулалтыг тусгаагүй, хандивтай холбоотой агуулгыг давхардуулан заасан, түүнчлэн хуулийн 10.1.5, 10.1.6, 26.3, 26.4, 26.5, 26.7, 26.8, 27.13-т заасан шаардлагуудыг намын дүрэмд тусгаагүй орхигдуулсан, намын санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтан нь аль нэг аж ахуйн нэгж, байгууллагад санхүүтэй холбогдсон ажил, албан тушаал эрхлэх, төрийн алба, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд давхар алба хашихыг хориглох, намын дүрмийн зарим заалтууд нь утга, агуулга, дугаарлалт давхардсан” зэрэг зөрчлийг дурдан буцаажээ.

Дээрх зөрчлийг арилгахаар тус намын ээлжит 9 дүгээр Их хурал 2026 оны 03 дугаар сарын 14-ний өдөр дахин хуралдаж, намын дүрмийг шинэчлэх асуудлыг хэлэлцэж, хуралдаанд оролцсон 33 төлөөлөгчийн 96.7 хувийн саналаар дэмжин баталсан болох нь Тооллогын комиссын болон ээлжит 9 дүгээр Их хурлын 01 дүгээр шийдвэрүүд, хуралдааны тэмдэглэл, дүрс бичлэг болон бусад бичгийн баримтаар тогтоогдож байна.

Хоёр.Төлөөллийн төв байгууллагыг хуралдуулах болон намын шинэчилсэн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухайд.

2.1.Эрх чөлөөг хэрэгжүүлэгч намын дүрэм (2024 он)-ийн 4.1.1.2-т “Намын бүх шатны хурлын ирцийг гишүүд, төлөөлөгчдийн 50-иас дээш хувьтай бол тухайн

хурлыг хүчинтэйд тооцно”, 4.1.2.6.12-т “УТБЗ-ийн ээлжит, ээлжит бус хуралдааныг намын даргын эсхүл УТБЗ-ийн гишүүдийн гуравны хоёрын санал шаардлагаар УТБЗ 24 цагийн дотор зарлаж, хурлын шийдвэр нь намын дүрэм, хуульд заасны адил хүчинтэй үйлчилнэ” гэжээ.

Өргөдөлд хавсарган ирүүлсэн 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн Эрх чөлөөг хэрэгжүүлэгч намын ээлжит 8 дугаар Их хурлын 02 дугаар шийдвэрээр батлагдсан Улс төрийн бодлогын зөвлөлийн гишүүдээс намын дарга Ш.Төмөрсүхэд “намын төлөөллийн төв байгууллагыг хуралдуулах тухай” санал гаргасны дагуу тэрээр Улс төрийн бодлогын зөвлөлийн хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 11, 16-ны өдөр тус тус товлон зарлаж хуралдуулсан, энэ талаарх хурлын процесс зөрчилгүй байна.

2.2.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 17 дугаар зүйлийн 17.4-т “Намын төлөөллийн төв байгууллагын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно. Энэ нэмэлт, өөрчлөлт нь намын дүрмийн гуравны нэгээс хэтрэхгүй байна” гэж;

Эрх чөлөөг хэрэгжүүлэгч намын дүрэм (2024 он)-ийн 4.1.2.1-д “Улс төрийн бодлогын зөвлөл нь Их хурлын төлөөлөгчдөөс сонгож баталгаажсан тэргүүлэгч долоогоос /7/ доошгүй тооны гишүүнтэй байна ...”, 4.1.2.6-д “Улс төрийн бодлогын зөвлөл нь дараах асуудлыг өөрийн бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ”, 4.1.2.6.3-т “Улс төрийн бодлогын зөвлөл нь гишүүдийнхээ гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал намын дүрмийн гуравны нэгээс хэтрэхгүй хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх” гэж тус тус заажээ.

Эрх чөлөөг хэрэгжүүлэгч намын ээлжит 9 дүгээр Их хурлын 2026 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 01 дүгээр шийдвэрээр баталсан шинэчилсэн дүрэм нь 11 бүлэг, 499 зүйл, заалттай байсан, үүний 110 заалт буюу 21.5 хувьд нь намын Улс төрийн бодлогын зөвлөлийн 2026 оны 04 дүгээр сарын 11, 16-ны өдрийн хуралдаанаар нэмэлт, өөрчлөлт оруулсан нь хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-т нийцсэн байна.

Тухайн намын шинэчлэн баталсан намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Улс төрийн бодлогын зөвлөлийн 2026 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд 5 гишүүний 100 хувийн саналаар, 2026 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд 4 гишүүний 100 хувийн саналаар тус тус дэмжсэн болох нь Тооллогын комиссын 04 дүгээр тогтоол болон хуралдааны тэмдэглэлүүд, бичгийн бусад баримтаар тогтоогдож байна.

Иймд, Эрх чөлөөг хэрэгжүүлэгч намын 2026 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн ээлжит 9 дүгээр Их хурлын 01 дүгээр шийдвэрээр баталсан намын шинэчилсэн дүрэмд Улс төрийн бодлогын зөвлөлийн 2026 оны 04 дүгээр сарын 11, 16-ны өдрүүдийн 01 дүгээр шийдвэрээр нэмэлт, өөрчлөлт оруулсан, тухайн намын дүрэм нь бүхэлдээ Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан намын дүрэмд тавигдах нийтлэг шаардлага болон намын дүрмээр тусгайлан зохицуулах асуудлыг тусгасан тул бүртгэж шийдвэрлэв.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.5 дахь хэсэгт заасныг баримтлан Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам (ЭЧХН)-ын шинэчилсэн дүрмийг бүртгэсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

Ц.ЦОГТ